



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-7
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	8-17
<hr/>	
1. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/	10
2. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжлэв/	10
3. “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	11
4. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	11-12
5. “Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	12-13
6. “Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	13-16
7. “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	16-17

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 28-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 17 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Г.Ганболд, Б.Жавхлан, Ц.Сандаг-Очир, Б.Энхбаяр, Т.Энхтүвшин;

Чөлөөтэй: Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Т.Доржханд, М.Оюунчимэг, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Сэргэлэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Э.Бат-Амгалан, С.Батболд;

Тасалсан: С.Амарсайхан, Б.Дэлгэрсайхан, Ц.Мөнх-Оргил, С.Одонтуяа, Ц.Туваан, Н.Учрал;

Хоцорсон: П.Анужин -07 минут, Б.Баттөмөр -19 минут, Б.Баярсайхан -01 минут, Х.Булгантуяа -01 минут, Ц.Даваасүрэн -02 минут, Г.Мөнхцэцэг -09 минут, Д.Өнөрболор -35 минут, Д.Сарангэрэл -10 минут, Ж.Сүхбаатар -31 минут, Г.Тэмүүлэн -01 минут, Б.Энх-Амгалан -02 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Б.Пүрэвдорж нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Нэг.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 19

Бүгд: 45

73.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжлэв/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатангуул, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./10:28/

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Г.Занданшатар: “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 20
Бүгд: 46
56.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:29/

Уг асуудлыг 10 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, мөн газрын дэд дарга Г.Даваадалай, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Р.Батрагчаа, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, мөн газрын Сургалт, судалгааны хүрээлэнгийн захирал Б.Бат-Орших, Шүүхийн сахилгын хорооны Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга М.Мөнх-Алдар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан танилцуулав.

Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 15
Бүгд: 46
67.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа танилцуулав.

Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 16
Бүгд: 46
65.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Г.Дөлгөөн оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөгдөх тухай Г.Дөлгөөнөөс ирүүлсэн саналыг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нар танилцуулав.

Эрх бүхий албан тушаалтны санал болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Ганбямбын Дөлгөөнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	19
Бүгд:	44

56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2-г заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонх чөлөөлөх саналыг дэмжсэн тул Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:42/

Уг асуудлыг 10 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа. “Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх тухай Д.Занданбатаас ирүүлсэн саналыг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нар танилцуулав.

Эрх бүхий албан тушаалтны санал болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбатыг үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 12
Бүгд: 45
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2-г заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонх чөлөөлөх саналыг дэмжсэн тул Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:51/

Уг асуудлыг 10 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Долоо. “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж танилцуулав.

Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 9
Бүгд: 45
80.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан

асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:55/

Уг асуудлыг 10 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 38 минут үргэлжилж, 72 гишүүнээс 50 гишүүн хүрэлцэн ирж, 69.4 хувийн ирцтэйгээр 10 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 17 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданишатар: Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 дүгээрт Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Энэ дээр бол асуулт, хариулт дуусчихсан, санал хэлсэн, санал хураалт үлдсэн байгаа. 2 дугаарт Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тов зарлах, санал авах өдрийг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлж хэлэлцэнэ. 3 дугаарт “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. 4 дүгээрт “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт, нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. 5 дугаарт Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудал. 6 дугаарт Монгол Улсын ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудал. 7 дугаарт Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлын тов дарааллыг өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах болбол өмнөх

өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Цогт-Очирын Анандбазар, Ширнэнбаньдын Адьшаа, Бөхчулууны Пүрэвдорж нараас албан бичгүүд ирүүлсэн байна. Ингээд Цогт-Очирын Анандбазар гишүүн нэрээ татсан, хойшлуулсан байна. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн үг хэлнэ.

Ш.Адьшаа: Та бүгдийнхээ өнөөдрийн амар амгаланг айлтгая. Энэ Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад санал хэлэхээр ерөөсөө биелэгдэхгүй юм. Эрдэнэбүрэнгийн цахилгаан станц ирэх жилээс ажлаа эхэлнэ. Энэ нөлөөллийн бүсэд 1200 иргэн байгаа. Энэ 1200 иргэнд 30 сая төгрөгийн нөхөн олговор олгоё гэдэг Улсын Их Хурлын хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Чимэдийн Хүрэлбаатарын хамт өргөн мэдүүлээд нэг жил болж байна. Нэг жил болж байна, ерөөсөө хэлэлцэхгүй байна. Энэ төслийг явуулъя гэвэл тэр нөлөөллийн бүсэд байгаа ард иргэдийн асуудлын шийдэх ёстой. Энэ төслийн мөнгөнөөс 17 сая доллар байгаа, 360 сая долларын санхүүжилтээр шийдэгдэх гэж зээл авсан. Энэнээс 17 сая төгрөг байгаа, 51 тэрбум төгрөг байна. Энэ бүсэд амьдардаг энэ 1200 хүнд энэ мөнгийг нь яагаад өгчхөж болохгүй байгаа юм бэ? Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэнийхээ амьд явах, амьдрах орчныг сайжруулах, энийг Монголын төр хуулиар хариуцна гэсэн зарчим байгаа шүү дээ. Энэ асуудлыг яаралтай оруулж ирж хэлэлцүүлэхийг Улсын Их Хурлын удирдлагаас, Даргын зөвлөлөөс би бас хүсэж байна.

2 дахь асуудал 2010, 12 он, 16 оны сонгуулийн дараа Монгол Улсын иргэдийн сая гаруй иргэдийн 1072 хувьцааг сонгуульд зориулж, Монголын төр авсан байгаа. Энэ мөнгийг нь буцааж өгье, энэ хувьцааг нь буцааж өгье гэдэг Улсын Их Хурлын тогтоолын төсөл өргөн барьсан. Төсвийн байнгын хороогоор хэлэлцсэн. Гэтэл энэ сар гаруй.../үг тасрав/

Г.Занданшатар: Чуулганы нэгдсэн хуралдаанаар Байнгын хороогоор хэлэлцсэн асуудлын хэлэлцэх асуудалд тов дараалалд орсон асуудлыг л үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлж гэж байгаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: 4 дэх өдөр тойрог томсгосон тогтоолыг Улсын Их Хурал баталсан. 5 дахиад Говь-Алтай, Ховд, Увс аймгуудад ажиллаад ирлээ. Говь-Алтай аймгийн 1350 туульчид Жангар тууль хайлсан, 300 гаруй тэмээчид чуулсан том арга хэмжээ болсон. Тэгээд энэ арга хэмжээ дээр оролцсон Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Баянхонгор багийн Хоролсүрэнгийн Ивансан гуай Монгол Улсын боловсролын тогтолцоо нь хэтэрхий гаднын хуулбар ихтэй, тэр нь нутагшилт муутайн дээр манай орны соёл, иргэншил, ёс заншил, цаг агаар, уур амьсгалын эрс тэс байдал, таруу байрлал, нүүдлийн амьдрал зохицохгүйн улмаас хүүхдэд үр дүн багатай, Монгол ахуйгаас тасарсан зэрэг нь сургалтын чанарт муугаар нөлөөлж, алсдаа муу болж байна. Иймд Монгол ёс заншлыг, соёл, Монгол ахуйг суурилуулсан хэн нэгэн сайд нар нь гараад өөрчилж болдоггүй, тэгэхдээ тодорхой суурийг нь өөрчилж болдоггүй тодорхой өөрчлөлтүүдийг хийж болдог, Монгол хүүхдийн сургалтын хөтөлбөрийг бий болгож ажилла. Тэгээд болохгүй бол надаас зөвлөгөө ав гэж гэж байна шүү.

Улаангом сумын 7 дугаар багийн ахмад багш Д.Гүнсэл АНУ-ын Техас, Узбекистан, Монголын Улаангом гэдэг цөөхөн газар дээр бол яг энэ уур амьсгалын таатай орчноос болоод жимс ногооны үр гайхалтай боловсордог газар байдаг юм. Гэтэл энэ жимс ногооны үрийг боловсруулаад гаргах дээр хамгийн гол нь үнэ нь хангалттай биш байна. Тийм учраас Хүнс, хөдөө аж ахуйн яам тодорхой арга хэмжээ авч, янз бүрийн ченжгүйгээр энэ жимсний үрийг ард иргэдэд Монгол орон даяар тараахаар тараахад анхаараарай гэж хүсэж байна. Тэгээд энийг манай Болорчулуун сайд сонсоод сууж байна, та энийг арга

хэмжээ болгоорой гэж хэлье. Увс аймгийн Өмнөговь сумын Монголд хоёрхон байдаг сумд хоёрхон байдаг хувийн сургуулийн нэгнийх нь захирал Сүрэнгийн Өлзий манай сургууль 250 мянган төгрөгөөр хүүхдээ жилийн төлбөртэй авдаг. Тэгээд нөгөө Боловсролын ерөнхий хуулийн 38.5.5-д хувийн сургуульд үдийн хоолны мөнгө өгөхгүй, санхүүжилт өгөхгүй гэгчихсэн. Тэгээд 250 мянган төгрөгөөр яаж ингэж бүтэн жил тэр хүүхдүүдийг хооллох юм бэ, бид нар яаж цалингаа тавих юм бэ гэдэг ийм асуудлыг ярьж байна. Энийгээ өөрчилж өгөөч гэж хүсэж байна.

Ховд аймгийн Жаргалант сумын Рашаант багийн иргэн Монгол Улсын гавьяат багш Тогмидын Даваа Мягмар зааныг сурагч байхад баригдсан стадионыг минь шинээр барьж өгөөч. Дээрээс нь 20 дугаар сургуульд би олон жил багшилсан. Тэр 20 дугаар сургуулийн маань өргөтгөлийг шинээр барьж өгч, энэ хүүхдийн сурах орчныг таатай болгож өгөөч гэсэн ийм хүсэлт тавьж байна. Ховд аймгийн Дөргөн сумын Агваши багийн өндөр настан Энх-Амгалан гуай гахай ихдээд бог мал, ишиг, хурга идээд болохгүй байна. Тийм учраас цаг хугацаанд нь тэр гахайны зөвшөөрлийг нь өгөөд тэр одоо бүүр сүүлдээ айлын гэрт орж ирэх нь холгүй энэ хонь мал идээд байна. Тийм учраас энэ асуудлаа шийдвэрлэж өгөөч гэсэн ийм хүсэлт тавьж байна. Тэгээд олон, олон хүсэлтүүд гардаг. Энэ дээр бас яамдын сайд нар тодорхой арга хэмжээ авах ёстой. Би тэгээд энэ долоо, ирэх долоо хоногийн сүүлээр тодорхой албан бичгүүдийг нь бичээд, хариултаа нэхнэ, тэрний дагуу арга хэмжээ авсан байгаарай гэж хэлье. Ялангуяа Болорчулуун сайд. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Хэлэлцэх асуудалдаа оръё. Анандбазар гишүүн нэрээ татаад хойшлуулсан. Дараагийн чуулган дээр үг хэлэх юм байна лээ. Өнөөдөр хэлэлцэх асуудалтай холбогдохгүй учраас.

Нэг. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлж хэлэлцэнэ. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Хагас сайнд хуралгүй, Хагас сайн 31 байгаа биз дээ, 30 байгаа тийм. Байнгын хорооны саналаар Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. Байнгын хорооны саналаар Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ургамал хамгааллын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, 2.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал

хураалт явуулна. Гишүүд, санал хураалт. 57,8 хувийн саналаар санал дэмжигдэж, хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ.

Гишүүдийн олонх төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн учраас төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлж байна. Энэ Ургамал хамгааллын тухай хуулийг тариаланчид их ярьж байгаа юм байна. Энэ хаврын чуулганаас, юу хаврын тариалалтаас өмнө батлахгүй бол болохгүй байх шүү тийм ээ Батжаргал сайдаа, Батжаргал даргаа Байнгын хорооны дарга.

10.28 цаг

Хоёр. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжлэв/

Дараагийн асуудалд орно. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлж хэлэлцэнэ. Энэ завсарлагыг 2 удаа өгсөн. Завсарлага авах хугацаа дууссан байна. Цогтгэрэл дарга алга байна. Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа. Санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд товлон зарлах, санал өдрийг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Раднаасэд гишүүнээ санал хураалт, санал хураалт. Адьшаа гишүүнээ санал хураалт. 56,5 хувийн саналаар санал дэмжигдэж, дэмжигдэж тогтоолын төсөл батлагдлаа.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай Улсын Их

Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.29 цаг

**Гурав. “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Дараагийн асуудалд орно. Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Бямбасүрэнгийн Энх-Амгалан танилцуулна. Индэрт урьж байна. Байнгын хороо дуусчихсан уу?

Б.Энх-Амгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Монгол Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооноос ирүүлсэн саналуудыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу Хууль зүйн байнгын хорооноос боловсруулсан Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үеэр гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Хууль зүйн байнгын хорооноос боловсруулсан Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Байнгын хорооны саналаар Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Энхболд даргаа санал хураалт, суудалдаа сууцгаа, гишүүд суудалдаа. Санал хураалт, санал хураалт. Цогтгэрэл дарга санал хураалт. 67,4 хувийн саналаар санал дэмжигдэж, тогтоолын төсөл батлагдлаа. Гишүүд, Ажлын хэсэгт баярлалаа.

10.32 цаг

Дөрөв. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудалд орно. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьяа танилцуулна. Индэрт урьж байна.

Ш.Адьяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ерөнхий прокурорын ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу Хууль зүйн байнгын хорооноос боловсруулсан тогтоолын хавсралт нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 12 сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Байнгын хороонд хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үеэр гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно. Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Хууль зүйн байнгын хорооноос боловсруулсан Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсэг алга. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Цалин биш ээ. Байнгын хорооны саналаар Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Энх-Амгалан дарга суудалдаа. Энэ цалин биш ээ. 65,2 хувийн саналаар санал дэмжигдэж, тогтоолын төсөл батлагдлаа. Гишүүд, Ажлын хэсэгт баярлалаа.

10.34 цагт

Тав. “Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудалд оръё. Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрэм танилцуулна. Энэ өргөдлийг нь өгөөч. Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөгдөх тухай өргөдөл санал ирсэн байна. Энэ өргөдөл саналыг бол Эдийн засгийн байнгын хорооны саналаар хуралдаж, шийдвэрлэсэн дэмжсэн байна. Ганбаярын Дөлгөөн нь Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаар ажиллаж? ажилласан хугацаандаа ажлын амжилт бүтээл гаргаж, ФАТФ буюу саарал жагсаалтаас гаргах, банкны салбарын реформыг хэрэгжүүлэх, банкуудын хяналт шалгалтыг эрчимжүүлэх, банкуудын хувьцаа гаргах чиглэлээр их үр бүтээлтэй ажилласнаа онцлон тэмдэглээд, ажлаас хувийн шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан байна. Ийм өргөдлийг ирүүлсэн байна. Ингээд өргөдлийг яаралтай хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүссэн. 12 дугаар сарын 20-нд ийм өргөдөл ирүүлсэн байна. Ингээд энэ саналыг Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцээд санал, дүгнэлтээ гаргасан байна. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг, яасан бэ? Чинбатын Ундрэм гишүүн танилцуулна.

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайдаа сая таны эзгүйд өглөө энэ цэцэрлэг, сургуулийн хүүхдийн үдийн хоолны төсвийг нэмэх асуудлыг яриад байна. Энэ дээр дэг журмын дагуу Улсын Их Хурлаас ажлын хэсэг байгуулж, ямар нэмэлт нөхцөл төсөв батлагдсан ч гэсэн нөхцөл боломжийг харгалзаж үзэхгүй бол жилийн 250 мянган төгрөгөөр, жилийн 250 мянган төгрөгөөр бүхэл бүтэн сургуулийн үдийн хоолны төсвийг яаж шийдэх вэ гэсэн ийм саналыг сая гишүүдээс ярилаа шүү. Энэ бас D-parliament системээр цэцэрлэг, сургуулийн хүүхдийн үдийн хоолны төсвийг нэмэх тухай асуудлыг шийдвэрлэх санал ирээд, 61 мянган хүн одоогоор дэмжсэн. Ажлын хэсэг байгуулах шаардлагатай гэж үзсэн байна. Ирэх оны төсвөөс байдаг юм уу, энэ жил төсвийн ерөнхийлөн захирагч дотор шилжүүлэх ямар бололцоо байна.

Ингээд Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам танилцуулна.

Ч.Ундрам: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Ганбямбын Дөлгөөнөөс 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хурлын даргад ирүүлсэн Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтийг Эдийн засгийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1 дэх хэсэгт заасныг баримтлан Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь уг саналыг дэмжиж, Ганбямбын Дөлгөөнийг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасныг баримтлан Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хорооноос боловсруулсан бөгөөд тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108.2-т

нэгдсэн хуралдаанд эрх бүхий албан тушаалтныг санал, холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, нууц санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх томилох, чөлөөлөх саналыг дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно гэж заасны дагуу санал хураалтыг нууцаар явуулна. Ганбямбын Дөлгөөнийг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна. Гишүүд суудалдаа. Сарангэрэл гишүүн, Энхболд гишүүн. Санал хураалт. Энэ шалгалтын санал хураалт, энэ нууц санал хураалтын горимыг хянаж байгаа юм. Үгүй ээ болоогүй, болоогүй. Сая би албан ёсны санал хураалт гээгүй, биш, биш. Чи яасан бэ, наадхаа хэлээч. Нууц санал хураалтын горимын бэлтгэл хангагдаагүй байна гэдгээ хэлэхгүй яасан юм бэ? Энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Бэлэн болохоор хэл. Нууц санал хураалтын техникийн бэлтгэл хангагдсан байна.

Ингээд Ганбямбын Дөлгөөнийг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулъя. Нууц санал хураалтыг явуулъя. 56,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Түрүүн болбол би туршилтын санал хураалт гээд санал хураалт явсан. Нууц санал хураалтынх болохоор тэгж би санал хураалгасан шүү. Чөлөөлөх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Тогтоолын төсөл батлагдлаа.

10.42 цаг

Зургаа. “Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх

тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуулт орно. Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ. Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай саналыг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа. Доржсүрэн овогтой Занданбат миний бие Улсын Их Хурлаас 2019 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 48 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий аудитораар томилогдон ажиллаж байна. Миний бие 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшихээ илэрхийлж, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29.4, Төрийн аудитын тухай хуулийн 30.1.2-т зааснаар албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтийг гаргаж байна. Хүсэлтийг хүлээн авч, холбогдох хуулийн хүрээнд шийдвэрлэж өгнө үү. Өргөдөл гаргасан Доржсүрэнгийн Занданбат гэсэн байна. Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн гишүүн танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбатаас 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хурлын даргад ирүүлсэн хүсэлтийг Төсвийн байнгын хороо 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат нь Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Төрийн аудитын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэг ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн байна. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд

асуулт асууж, үг хэлээгүй болно. Байнгын хорооны хуралдаанаар Занданбатыг Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэхэд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Та бүхнийхээ өглөөний амар амгаланг айлтгая. Ингээд бас янз бүрийн шалтгаар хүмүүс ажлаас гарч, чөлөөлөгдөж ингээд л явдаг л даа. Сая харин орж ирж байхад би Занданбат даргыг харлаа. Ингээд ажлаас чөлөөлөгдөхдөө бас ингээд орж ирээд, бас гишүүдийн асуултад хариулаад ингээд явдаг ийм хүмүүс цөөхөн байдаг. Тэгээд нөгөө усанд хаясан чулуу шиг л алга болчихдог төрийн ажлыг хийж байгаад. Энэ жишиг бас буруу жишиг юм бас. Монголын ард түмэн, Монгол Улсын төр, Их Хурлын гишүүд бол бас ажил төрөл нь ямар байсан, яаж байсан, ийж байсан гэдгийг бол бас ярилцаад, нөгөө явах ажлаа хийж байсан хүн нь бас захих хэлэх юм байдаг юм бол хэлээд ингэж явж байх ёстой л доо.

Би Занданбат даргыг бол энэ өөрийнхөө ажиллах хугацаандаа бол нэлээн сайн ажилласан. Төрийн хүний бас нэг зангаргатай энэ ажлаа бол гайгүй

хийсэн гэж бодож байна. Ялангуяа тэр аудитын дүгнэлтүүд бол энэ төсөв дагаад сүүлийн хэдэн жил бол нэлээн сайн гарч байсан. Манайхан л хэрэгжүүлдэггүй болохоос биш. Бид бүхэн бас энэ дээр бол анхаармаар юм билээ. Нөгөө талаар бол сая ингээд улсын төсөв баталж байхад бол бас дутуу, хийгдээгүй, гүйцээгдээгүй ажлыг хийх энэ юмыг бол бас их зөв зүйтэй талаас нь харж ингэж ажилласан гэж бодож байна. Тэгээд ер нь аудитын байгууллага маань ер нь та ингээд ажиллалаа, цаашидаа одоо бас ерөнхийдөө ямаршуухан байж, ямаршуухан ажиллавал ер нь зүйтэй байна гэдэг талаар та бас нэг өөрийнхөө санал бодлыг бас нэг товчхон хэлчихнэ үү гэсэн ийм хүсэлт байна, тийм. Занданшатар дарга ажлаа хийе, би асуултаа асуучихлаа. Та 2 тэр нарийн ширийн юмаа орой гэртээ ярьдаг юм байгаа биз.

Г.Занданшатар: Та асуултаа дуусгая, та чинь сүүлийн нэг секундэд гол юмаа асуудаг учраас хүлээж байна шүү дээ. 85 Доржсүрэнгийн Занданбат хариулъя.

Д.Занданбат: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Ганбат гишүүний асуултад хариулъя. 2019 оны 5 сард Монгол Улсын Ерөнхий аудитораар томилогдсон. 4 жил гаруй энэ ажлыг хийж байна. Аудитын ажил бол өөрөө бас их хариуцлагатай. Өөрөөр хэлбэл хяналтын тогтолцооны дээд байгууллага гэж олон улсынхаа тэр аудитын ойлголтоор тэгж ойлгодог. Миний ажилласан гол чиглэл бол аудитын чадавхыг сайжруулъя. Дээрээс нь энэ хяналтын ажлын хараат бус бие даасан байдлыг бас хангахын төлөө зорьж ажилласан. Энэ ажиллаж байсан хугацаанд бол Улсын Их Хурал маань бас дэмжлэг үзүүлж, Үндсэн хуулийн байгууллага болгож бас Үндсэн хууль дээр төрийн хяналтыг төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх ийм хууль, эрх зүйн орчныг бий болгож өгснөөрөө бас их түүхэн үйл явдал нь. Үүнтэй нийцүүлээд Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн

найруулгыг хийсэн. Үүгээрээ бол хараат бус байдлаа аль болохоор хангах ийм зорилготойгоор юу ийм эрх зүйн орчныг бий болгож явсан явдалд бол Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд бол их талархаж байдаг.

Аудитын чадвар буюу аудитын ёс зүйн талбарын үйл ажиллагааг бол нэлээн эрхэмлэж хийсэн. Энэ дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийг гаргасан. Сургалт, хөгжлийн төлөвлөгөө, Байгууллагын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө гэх мэтчилнээр бодлогын шинж чанартай бичиг баримтуудыг нэлээн гаргаж хийсэн. Тэгээд гишүүдэд хийсэн 4 жилийн хугацааны танилцуулгыг бас бичгээр хүргүүлчихсэн байгаа учраас бас нуришлгүй товчхондоо бас та бүхний дэмжлэг туслалцаатайгаар төрийн хяналтын үйл ажиллагааг боломжийн түвшинд авч явсан байх гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн. Дараа нь санал хураалт.

Б.Баттөмөр: Занданбат дарга ингээд ажлаа өгч байна. Занданбат даргын хувьд болбол өнгөрсөн энэ 4 жилд шахуу хугацаанд ажиллахдаа маш сайн ажилласан. Энэ Монголын нийгэмд энэ болж байгаа энэ хууль бус үйлдлүүдийг манай аудитын байгууллагууд бол тухай тухайн үедээ шалгаад, үзээд, хараад, дүгнэлтүүдээ гаргаад өгчихсөн байдаг юм. Тэгээд харамсалтай нь бид нар энэ аудитын байгууллагынхаа дүгнэлтүүдийг сайн уншиж, тэрний мөрөөр ажиллаагүйтэй холбогдуулаад энэ зөрчил дутагдлууд болбол гарсан гэж ингэж үзэж байгаа.

Би бас Занданбат даргатай татварын байгууллагад хамтарч ажиллаж байсан. Занданбат дарга болбол маш их тийм мэдлэгтэй, туршилагатай, тэгээд хамт олныг сайхан бүрдүүлдэг, ёс зүй өндөртэй их сайн ийм боловсон хүчин. Өнөөдөр энийг ажлаа өгч байгаа учраас хэлэх ёстой. Монголчууд

нэг хэлдэг шүү дээ. Нэг өмсөөд баймаар хуучин хувцас, уулзаж яриад баймаар нэг төлөв төвишин хүн гэж. Яг тийм хүн болбол манай Занданбат дарга юм. Тэгээд Занданбат дарга болбол энэ аудитын байгууллагад бол маш их тийм шинэчлэлүүдийг хийсэн. Энэ орчин үеийн энэ цахим болох, тэгээд аудитын ажилтнуудынхаа мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, хамт олон бүрдүүлэх, дүгнэлтийг их ил тод гаргах энэ чиглэлд бол их том амжилтуудыг гаргасан гэдгийг би их сайн мэднэ. Ингээд надад бол асуулт алга. Занданбат даргадаа цаашдынх нь ажилд улам их амжилт хүсье.

Г.Занданшатар: Санал хураалт явуулна. Нууц санал хураалт явуулна. Нууц санал хураалтаар гишүүдийн олонх томилох санал, чөлөөлөх саналыг дэмжсэн бол тухайн тогтоол батлагдсанд тооцно гэж заасны дагуу санал хураалтыг нууцаар явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Доржсүрэнгийн Занданбатыг Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулъя. 73,3 хувиар санал дэмжигдэж, Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо. Чөлөөлөх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Тогтоолын эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.51 цаг

Долоо. “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудалд орно. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх

Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно. Байнгын хорооны хуралдаанаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Байнгын хорооны саналаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Цэрэнпунцаг даргаа, та 2 санал хураалтад. Занданбат гуай хүлээж байгаарай та. Санал хураалт. 80 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

10.55 цаг

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дуусаж байна. Одоо Даргын дэргэдэх, Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл хуралдана. Баттөмөр гишүүн, Цэрэнпунцаг гишүүн, Батжаргал гишүүн, Тэмүүлэн дарга, Байнгын хороод, Баярсайхан дарга. Одоо Даргын дэргэдэх зөвлөлийн хуралтай. Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ*

БУУЛГАЖ, ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

